



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 09 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

### ХЭЛЭЛЦСЭН нь:

Эрүүл мэндийн даатгалын сангийн авлагад суутган тооцож хөрөнгө хүлээн авах тухай

### ТЭМДЭГЛЭСЭН нь:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А-96 дугаар тушаалаар “Капитал банк” ХХК-ийг албадан татан буулгахаар шийдвэрлэж, мөн өдрийн тушаалаар Банкны эрх хүлээн авагч томилж, Эрх хүлээн авагч нь банкны хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хадгалах, хамгаалах, худалдан борлуулах, иргэд болон төрд учирсан хохирлыг барагдуулахаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /Эрүүл мэндийн даатгалын сан/ татан буугдсан Капитал банкинд хадгалагдаж байсан хугацаатай мөнгөн хадгаламж, хуримтлагдсан хүүгийн нийт 134,909,998,200.00 /нэг зуун гучин дөрвөн тэрбум есөн зуун есөн сая есөн зуун ерэн найман мянга хоёр зуун/ төгрөгийг гаргуулахаар Банкны тухай хуулийн 71.1-д заасны дагуу банкны Эрх хүлээн авагчид хандан нэхэмжлэл гаргаж, авлагыг баталгаажуулсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 2.8-д зааснаар “Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Банкны эрх хүлээн авагч нартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, татан буугдсан банкны чанааргүй активыг шуурхай барагдуулах, төлбөрт хураагдсан үл хөдлөх эд хөрөнгө болон улсын орлогод хураагдсан эд хөрөнгөөс олсон орлогыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эмнэлэг, сургууль, улсын хэрэгцээнд ашиглах” талаар шуурхай арга хэмжээ авч ажиллахыг холбогдох албан тушаалтуудад даалгасан.

Энэ ажлын хүрээнд Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагчийн зүгээс үл хөдлөх хөрөнгийг татан буугдсан Капитал банкнаас төлөх өр төлбөрийн зарим хэсэгт тооцож, шилжүүлэн өгөх тухай саналтыг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 3438 дугаар албан бичгээр 86 нэрийн хөрөнгө санал болгон хүргүүлсэн байна.

### ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Эрүүл мэндийн даатгалын сангийн Капитал банкин дахь хугацаатай мөнгөн хадгаламжийн авлагын зарим хэсэгт тооцож тус Банкны эрх хүлээн авагчаас санал

болгосон үл хөдлөх хөрөнгийг хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шилжүүлэн авахыг зөвшөөрөв.

2.Банкны эрх хүлээн авагчтай тохиролцон хүлээн авсан хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын сангийн эргэлтийн хөрөнгийн “борлуулах зориулалттай үндсэн хөрөнгө” дансанд бүртгэж, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орлогыг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх нь зүйтэй “ гэжээ.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

